

МОНГОЛ УЛСЫН ЭРТНИЙ ЭРХ ЗҮЙН ЭХ СУРВАЛЖИД ГЭР БҮЛИЙН ДУНДЫН ЭД ХӨРӨНГИЙН ТАЛААР ТУСГАСАН НЬ

О. Отгонтуяа
Дотоод хэргийн их сургуулийн
Эрх зүй, нийгмийн ухааны сургуулийн
Хувийн эрх зүйн тэнхимийн ахлах багш,
доктор, цагдаагийн хошууч

Товч агуулга: Монгол Улс төрт ёс, эртний эрх зүйн эх сурвалжийг дээдлэн ирсэн түүхэн уламжлалтай бөгөөд түүхэн хөгжлийнхөө явцад иргэний эрх зүй, гэр бүлийн эрх зүй, өмчийн эрх зүйн харилцааг Монголын нууц товчоо, Их засаг, Юань гүрний нэвтэрхий хууль, Алтан хааны цаазын бичиг, Халхын цааз эрхэмжийн бичиг, Монгол-Ойрадын цааз, Халх журам, Зарлигаар тогтоосон Монгол Улсын хууль зүйлийн бичиг зэрэг эртний бичигт зан заншил, дэг журам, ертөнцийг үзэх үзэлтэй уялдуулан зохицуулсан байна. Дээрх эртний эрх зүйн эх сурвалжид гэрлэлтийн харилцаа, үрчлэлтийн харилцаа, тэжээн тэтгэх харилцаа, өв залгамжлалын харилцааны талаар хэрхэн зохицуулж байсныг төрөлжүүлэн судаллаа.

Түлхүүр үгс: Эртний эрх зүйн эх сурвалж, гэрлэлтийн харилцаа, гэр бүлийн дундын хөрөнгө, өв залгамжлалын харилцаа, хүүхэд үрчлэх, тэжээн тэтгэх харилцаа.

Оршил:

Монгол Улс төрт ёс, эртний эрх зүйн эх сурвалжийг дээдэлж ирсэн түүхэн баялаг уламжлалтай бөгөөд тэдгээр нь үе үеийн цааз бичиг, хууль тогтоомжуудад хадгалагдан иржээ. Монголын төрт ёсны тухай академич Ж.Болдбаатар Их засаг хууль нь “төр”, “улс” гэдэг ухагдахууныг жинхэнэ байх ёстой утгаар дэлхийн олон үндэстэн угсаатанд ойлгуулж өгсөн төдийгүй өрнө, дорныг ойртуулан даяаршуулах эрх зүйн үндсийг бүрдүүлж өгсөн онцгой ач холбогдол бүхий цаазыг эрхэмлэж байлаа¹⁸⁸ гэж онцлон тэмдэглэсэн байдаг.

Манай улсын эрдэмтэн, судлаачид ¹⁸⁹ Монгол Улсын эртний хууль тогтоомжуудыг судлахдаа тухайн цаг үеийн нөхцөл байдал, төрийн дэглэм, хууль тогтоомжийн хөгжил зэрэг хүчин зүйлүүдийг харгалзан

- Монгол нутагт төр үүссэн цагаас хойш XIII зууны эхэн үе (Их Монгол Улс оршин тогтнож байсан);

- XIII зууны сүүлээс Монгол оронд Үндэсний ардчилсан хувьсгал ялсан 1921 он хүртэлх үе;

- 1921 оноос 1990-ээд оны үе;

- Ардчилсан шинэчлэл өрнөсөн 1990 оноос хойших үе гэсэн үечлэлд ихэвчлэн хувааж үздэг.

¹⁸⁸ Болдбаатар Ж. Монголын төр ёсны уламжлал, шинэчлэлийн асуудлууд. Монголын төр, эрх зүйн түүхэн уламжлал, орчин үе. Олон улсын Эрдэм шинжилгээний бага хурал. Уб., 2006. 11 дэх тал.

¹⁸⁹ Лүндээжанцан Д. Болдбаатар Ж. Монгол Улсын төр, эрх зүйн түүхэн уламжлал. Уб., 1997. 9 дэх тал.

Манай улсын орчин цагийн иргэний эрх зүйн үндэс болсон “тэгш эрх бүхий эрх зүйн субъектүүдийн хооронд үүссэн эд хөрөнгийн харилцааг зохицуулж эхэлсэн анхны системчилсэн ¹⁹⁰ , салбарын хууль ¹⁹¹ болох 1926 оны Бүгд Найрамдах Монгол Ард Улс (цаашид БНМАУ гэх)-ын Иргэний хуулийн хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн он цагийг эхлэл болгон

- 1926 оноос өмнөх үеийн эрх зүйн зохицуулалтын уламжлал;
- 1926 оноос 1992 он хүртэлх үеийн эрх зүйн зохицуулалтын уламжлал;
- 1992 оноос одоог хүртэл үеийн эрх зүйн зохицуулалтын уламжлал гэсэн

үечлэлийн хүрээнд судаллаа.

Монгол Улсын төрт ёс, цааз бичгийн сэтгэлгээ нь 2230 гаруй жилийн түүхтэй бөгөөд түүхэн хөгжлийнхөө явцад иргэний эрх зүй, гэр бүлийн эрх зүй, өмчийн эрх зүйн харилцааг Монголын нууц товчоо, Их засаг, Юань гүрний нэвтэрхий хууль, Алтан хааны цаазын бичиг, Халхын цааз эрхэмжийн бичиг, Монгол-Ойрадын цааз, Халх журам, Зарлигаар тогтоосон Монгол Улсын хууль зүйлийн бичиг зэрэг эртний бичигт зан заншил, дэг журам, ертөнцийг үзэх үзэлтэй уялдуулан зохицуулсан ба эдгээр хуулиудыг манай хуульч, эрдэмтэд Монгол хууль гэж нэрлэдэг ба монгол ахуй, монгол хүний оюун санааны хэрэгцээнээс урган гарч тэдгээрийн үзэл бодол, зан заншлын хэм хэмжээтэй хослон үйлчилж амьдралын хэвшил болсонтой холбоотой¹⁹². Оросын эрдэмтэн, монгол цаазыг судлаач И.М.Майский “Великаяяса” буюу Их засаг хууль нь тэр үеийн Их Монгол Улсын Үндсэн хууль¹⁹³ гэж дүгнэжээ.

Монголын нууц товчоо/ХШ зууны түүхэн үйл явцыг уран зохиолын аргаар дүрсэлсэн эртний эх сурвалжийг салбар эрх зүй бүрээр ангилсан түүхэн эх сурвалж юм ¹⁹⁴ .Уг бүтээлд шинээр тогтоосон заалтууд байхын зэрэгцээ монголчуудын эртнээс ахуй амьдралдаа хэрэглэж хэвшсэн заншлын хэм хэмжээг уран сайхны аргаар дүрсэлсэн билээ.

Монголын нууц товчоонд эд хөрөнгө шударгаар олж авах нэг арга нь дайн байлдаанд ялагдсан овог, аймаг, иргэдийн эд юмсыг Чингис хааны зарлигаар тогтоосон дэг журмын дагуу эзэмдэн авдаг байсан ба энэ нь өмчлөх эрхийг үүсгэж байна. Жишээ нь, Чингис хаан 1202 онд Татартай байлдахын өмнө дайсныг дарах цагт олзонд бүү саатагтун, дайсан нэгэнт дарагдвал тэдний юм хэзээ ч бидний олз болох тул хуваалцаж амжина гэж цааз тогтоосон.

Чингис хаан төрд үнэнч зүтгэж гавьяа байгуулсан зарим хүмүүс олсон олзоо хаанд бус шууд хувьдаа өмчилж болохыг хааны зарлигаар тогтоосон бөгөөд энэ нь тухайн үеийн өмчийн харилцаа үүсэх өвөрмөц хэлбэр байжээ. Жишээ нь, Сорхон шар, Бадай, Хишилиг та гурав олон дайсанд довтолж олз олвол олсноо бүрэн автугай, аян ав хийж ан гөрөөс албал алснаа бүрэн автугай.

¹⁹⁰ Мөнхжаргал Т. Гэр бүлийн эрх зүй. Уб., 1995. 8 дах тал.

¹⁹¹ Буянхишиг Б. Иргэний эрх зүйн удиртгал, Уб., 2012. 26 дах тал.

¹⁹² Авирмэд Э. Дашцэдэн Д. Совд Г. Монгол хууль. Уб., 1997. 3 дахь тал.

¹⁹³ Майский И.М. Чингис хаан. Вопросы истории. 1962. №5.

¹⁹⁴ Дашням И. Чингисийн хаант улсын төр, хууль цааз.Уб., 1997. 29 дэх тал.

Тэмүжин Тоорил хаанд булган дах бэлэглэсэн, Тэмүжин Жамуха хоёр анх нөхөрлөхдөө цутгамал шагай, дуут сум харилцан өгч авалцаж анд нөхдийн холбоо тогтоосон зүйл буюу бэлэг дурсгал нь өмчийн нэг төрөл юм.

Энэ үед гэрлэлтийн дараах хэлбэрүүдтэй байжээ¹⁹⁵. Үүнд;

1. Эцэг, эхүүд хүү, охин хоёроо гэрлүүлэхээр урьдчилан тохиролцож худ ургийн холбоо тогтоох замаар гэрлэлтийн харилцаа үүсдэг байжээ. Тухайлбал, Есүхэй баатар Хонгирад аймгийн Дэйсэцэнтэй учирч түүний охин Бөртэг Тэмүжин хүүдээ гэргий болгохоор гуйвал Дэй сэцэн: олон удаа гуйлгаж өгвөл эрхэмлэгдэх, цөөн удаа гуйлгаж өгвөл доромжлогдох гэдэг боловч охин хүний заяа төрсөн үүдэнд өтлөхгүй тул охиноо өгье.

2. Бусдын авааль эхнэрийг хүчээр булаан авч гэрлэх явдал байсан. Тухайлбал, Алтан, Хучир нар харийн иргэнийг халдан довтолж хацар гуа хатдыг олзолж, хатир сайт агтыг хөөж авчирч өгье гэж тангараглаж байжээ.

3. Дайн тулаанд олон удаа эрэлхэг зоригтой байлдаж гавьяа байгуулсан хүнд охиноо өгч гэрлэлтийн харилцаа үүсгэж байв. “Алалдах өдөр амиа хайрлахгүй ачийг хүргэж, байлдах өдөр байраа алдахгүй баатарлагаар зүтгэсний төлөө Ибаба бэхи хатнаа Жорчидайд соёрхож өгөв” гэжээ.

4. Бусад овог, аймгийн удирдагчид албат, иргэдээ дагуулан үнэн сэтгэлээсээ дагаар ирж хүчин зүтгэсний илэрхийлсэн тохиолдолд охиноо өгдөг байжээ. Ойрадын Хутуга бэхи түмэн ойрдоо дагуулан ирсэн гэж түүний дүү Иналчид өөрийн Чэчэхэн охиноо өгөв. Чингис хааны Алалтун охинд гурван эр бий, эхний эр нь алтан төр, удаах нь ариун нэр, гутгаар нь авсан эр ба нэгэнт эр, эмийн барилдлага, худ ургийн холбоо тогтоосон эр нөхөртөө Монголын нэгдсэн төр улсын бодлогоос урваж тэрслэхгүй, итгэл, зүтгэлтэй ажиллахад үнэнч ханийн халамж, зөвлөмжөөр идэвхтэй нөлөөлж, өөрөө шулуун шударга, ёс журмыг баримталж явахад чиглэсэн улс төр, гэр бүлийн харилцааны гүн санааг агуулсан захиасыг өгч байжээ.

Дайны байлдааны үед дүрвэгсдийн гэр орон, буйранд орхигдсон хүүхдийг олж үрчилж байсан онцлогтой. Олон удаагийн дайнд ард иргэдийн амьдрал доройтох, өнчин хүүхэд, асрах хүнгүй ядуу буурай хүмүүс олширч байсан учраас тэдгээр хүмүүсийг тэжээн тэтгэх сан байгуулсан ба “Өнчдийг тэтгэх хишиг” гэж нэрлэсэн байна. Уг сан нь дайнд эрэлхэг тулалдаж яваад амь үрэгдсэн хүний үр хүүхдэд хишиг хүртэх зорилготой.

Нөхөргүй хүүхнээс хүүхэд төрөх эм, эр бололцох, инж өгөх болон үр хүүхдийн тухай заасан байсан. Монголчууд эр, эм бололцохдоо инжинд нь эд хөрөнгө өгөхөөс гадна эмэгтэй хүнийг өгдөг байсан. Энэ нь нууц товчооны 43 дугаар зүйлд тэр “Хабич эхийн инжинд ирсэн Боданчирын татвар эм билээ” гэснээр тодорхойлж батлагдаж байна.

Их засаг: Монголын нэгдсэн тулгар төр байгуулсны дараа буюу 1189, 1206 онуудад Их Монгол Улсын хаан Чингис өөрийн гаргасан цаазыг бичүүлж Их хуралдаагаар хэлэлцэж Их Монгол Улсын үндсэн эх сурвалж болох *Их засаг*¹⁹⁶

¹⁹⁵Мөнхжаргал Т. Монгол Улсын иргэний хууль цаазын товчоон. Уб., 2006. 66 дахь тал.

¹⁹⁶Амарсанаа Ж. нар. Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхтгэл. I боть.Уб., 2010. 29-31 дэх тал.

нэртэйгээр тунхаглажээ. Монгол Улсын эрх зүйн хөгжлийн шинэ үеийг нээсэн анхны цааз бөгөөд түүний дотор хувийн өмчийг хамгаалах талаар тусгасан томоохон баримт бичиг бий¹⁹⁷. Уг цаазын бүтэц нь:

- Оршил хэсэг (нэгдсэн төр улсын мөн чанар, цаазын хүч чадал);
- Улсын хаан өргөмжлөх ёс, төрийн байгуулал, цэргийн ангийн бүтэц;
- Эрүүгийн хуулийн холбогдолтой заалтууд;
- Ард иргэдийн төлөх албан гувчуурын тухай;
- Олон улсын харилцаа, элч төлөөлөгчдийн тухай;
- Гэр бүл, иргэний тухай;
- Шашин суртахууны тухай;
- Мал аж ахуй, түүний бэлчээрийн тухай зэргээс бүрдэнэ¹⁹⁸.

Гэр бүлийн дотоод дэг журмын талаар “хүүхэд нь эцэг, эхээ, эхнэр нь нөхрөө үл сонсвол хуулийн хариуцлага хүлээлгэнэ” гэж заасан. Энэхүү зохицуулалтын зорилго нь Монголын төрийн үндэс айл, өрх бөгөөд түүнийг дээдэлсэн төрийн бодлогын үзэл санаа дэвшүүлсэн байна. Иймд өрхийн тэргүүнийг төрийн төлөөлөгч болгож, эрхийг нь хуулиар хамгаалж, оногдох үүргийг нь зааж өгсөн. Монгол төрийн тулгуур нь өрхийн тэргүүн аав, сурган хүмүүжүүлэгч ээж, ах, дүүс, төрөл төрөгсөд, ахмад настай хүмүүс, ноёд, түшмэл юм гэжээ¹⁹⁹.

Их засагт өв залгамжлалын талаарх түшмэд, ноёд буюу ард иргэд үхсэн хойно түүний хөрөнгө хэдий байсан ч хөндлөнгөөс ингэ тэг гэж үл болох бөгөөд хэн ч түүний эд хөрөнгөд халдаж болохгүй. Нас барсан хүн хэрвээ залгамжлах үр хүүхэдгүй бол түүний эд хөрөнгийг үнэнч шавь буюу зарцад нь өгөхөөс биш улсын сан хөмрөгт оруулж огт болохгүй” гэж заасан байна. Уг хуулиар өрхийн тэргүүн нас барсны дараа ууган хүүд бусдаас илүү хуваарилах зарчмаар өмчийг хуваана. Отгон хүүд гэр, мал сүргийг оролцуулан гал голомтыг өгөх тухай заасан байдаг. Мөн татвар(хууль бус эхнэр) эмээс төрсөн хүүхдүүд хууль ёсны хүүхдийн нэгэн адил эрхтэй гэж тэмдэглэснээс үзэхэд өвлөх эрхийн харилцаанд гэр бүлийн гишүүд тэгш эрхтэй оролцох баталгаа байсныг гэрчилж байна²⁰⁰.

Хөвгүүд, охид нь эцэг, эхээ үл хүндлэгсэд гэргий нь эрийнхээ зарлигийг үл дагагсад ба харьяат иргэд нь захирагчаа үл хүндлэгсдийг хүндээр шийтгэмой гэж тусгасан нь бие биенээ хүндэтгэх ёс журмыг тогтоосонд оршино.

Гэр бүлийн харилцаанд оролцогчдийг тэтгэх талаар 23 дугаар зүйлд өтгөсийг хүндэлж, ядуусыг тэтгэх хэрэгтэй. Богд, мэргэдийг хүндэтгэх хэрэгтэй гэж тогтоожээ.

Нэг нөхөр, олон эхнэртэй байх буюу полигам хэлбэрийн гэрлэлтийг хүлээн зөвшөөрсөн байна. Тухайлбал, Эр хүний санаа зоргоор олон эхнэр авч

¹⁹⁷Ням-Осор Н. Мөнх тэнгэрээс соёрхсон Чингис хааны зарлиг буюу Их засаг хуулийн тайлбар. Уб., 2003. 109-110 дахь тал.

¹⁹⁸Авирмэд Э. Дашцэдэн Д. Совд Г. Дурдсан бүтээл. 21 дэх тал.

¹⁹⁹Батбаатар А. Монгол Улсын гэр бүлийн эрх зүйн зарим асуудал. Уб., 2007. 48-49 дэх тал.

²⁰⁰Рязановский В.А. Монголчуудын хууль цаазын дурсгал бичгүүдийн түүхэн тойм. Их засаг хууль. Уб., 2000. 10 дахь тал.

болно. Анхны гэргий нь эрхэм хүндтэй, онцгой эрхтэй байна. Энэхүү эрх нь бас түүний үр хүүхдүүдэд хамаарна²⁰¹.

Ах нь нас барвал дүү нь, дүү нь нас барвал ах нь эхнэрийг нь гэргий болгон авах бүрдээ хуримын ёслол хийнэ гэсэн нь нийгмийн амьдралыг эмх цэгц, зохион байгуулалтад оруулж, засан сайжруулахтай холбоотой ойлголт юм. Ах дүү нараас хэн нэг нь нас барж, үр хүүхэд өнчирч бэлэвсэн эхнэр нь хүүхдээ дагуулаад хэн нэгэн зан заншлыг мэдэхгүй харийн хүнд очно гэдэг хүүхдийн хүмүүжлийн хувьд байж болшгүй зүйл гэж үздэг байсан учраас үр хүүхдээ хойд эцгийн гар харуулахгүй эцэг, эхээс дутуугүй ах, дүү, төрөл төрөгсдийнх нь хүрээлэлд байлгаж зөв зохистой өсгөн хүмүүжүүлэхэд уг заалт чиглэгдэж байсан байна.

Нас барсан дүүгийнхээ эхнэрийг гэргий болгон авч хурим хийнэ гэдэг нь ах, дүү, төрөл төрөгсөдөө цуглуулж гэр бүл, үр хүүхдийг нь өөрийн үр хүүхдээс дутуугүй харж хамгаалж явна гэдгээ нийгэм, олон түмний андгайлж байгаа ариун ёс журам юм.

Их засагт эх нь хүүхдээ алсан үед хэрхэн хариуцлага тооцох талаар тодорхой тусгаагүй харин гажуу солгой аргаар бусдыг алагсдын алмой, хүнийг алсныг алмой (торгож болно) гэж заасан²⁰².

"... Хүн бүр эхнэр авах ёстой бөгөөд нэг, хоёрдугаар үеийн төрөл садантайгаа гэр бүл болохыг хориглоно. Эр хүн эгч, дүү хоёрыг эхнэрээ болгож болохоос гадна хэдэн ч татвар эмтэй байж болно", "... Боол эмэгтэйгээс төрсөн хүүхдийг хууль ёсны эхнэрээс төрсөн хүүхдийн адил үзнэ. Анхны эхнэрийн хүүхэд бусад эхнэрийн хүүхдүүдээс дээгүүрт тавигдах ба өв залгамжилна", "Эмэгтэй хүн эд хөрөнгөнийхөө талаар санаа тавьж, юм худалдан авч, хүссэн зүйлээрээ наймаа хийж болно. Эрчүүд зөвхөн ан ав, аян дайныг л эрхэлнэ", "Балчир хүү, охин хоёртой хоёр айл өрх хоорондоо худ ураг болохыг хүсвэл сүй тавьж болно"²⁰³ гэж гэр бүлийн эрх зүйн үндсэн ойлголт болох гэр бүл болох нөхцөл, гэрлэхэд хориглох шалтгаан, гэр бүлийн дундын эд хөрөнгийн эрх, түүнийг хэрэгжүүлэх нөхцөлийг тодорхойлсон чухал заалтууд байжээ.

Их засгийн дараа Их Юаны нэвтэрхий толь, Арван буянт цагаан түүх, Их Юаны улсын цаазын бичиг, Алтан хааны цааз бичиг, Халхын шинэ олдсон цааз эрхэмжийн 18 хууль, Монгол-Ойрадын хууль зэрэг цаазын бичгийг мөрдөж байсан түүхтэй.

Юань Улсын хууль цааз: Их Юань гүрний үед Их засгийн дараа залгамж хаадын гаргаж байсан хууль дүрмүүдийг нэгтгэсэн хууль болох "Их Юань Улсын нэвтэрхий хууль", "Их Юань Улсын хууль цаазын бичиг" зэрэг цаазын томоохон бичгүүдийг эмхэтгэн гаргасан нь бүхэлдээ эзэнт гүрний эрхийн харилцааг зохицуулахад чиглэгдэж²⁰⁴ зэрэгцэн үйлчилж байжээ. Их Юань Улсын нэвтэрхий

²⁰¹Мөнхжаргал Т. Дурдсан бүтээл. 58 дахь тал.

²⁰²Эзэн Богд Чингисийн Их засаг. Уб., 1995. 55 дахь тал.

²⁰³Сүхбаатар З. Батбаяр Б. нар. Монгол Улсын Иргэний хууль тогтоомж, түүхэн эмхтгэл. Уб., 2012. 25 дахь тал.

²⁰⁴Бадарчи С. Их Монгол Улсын шүүх, шүүгчид, шүүгчдийн үйл ажиллагаа //Гэмт явдалтай тэмцэх асуудал. Онол арга зүйн улирал тутмын сэтгүүл. 2007. № 2 (20). 212 дахь тал.Авирмэд Э. Дашцэдэн Д. Совд Г. Дурдсан бүтээл. 30 дахь тал.

хууль нь олон дүрэм, журмаас 1320 онд 2539 хууль дүрмийг эмхтгэсэн байна. Юань улсын хууль нь феодалын бусад улс оронд үйлчилж байсан хуулиудын нэгэн адил нийлмэл бүтэцтэй өөрөөр хэлбэл орчин үеийн хуулиудтай адил төр, захиргаа, иргэн. эрүүгийн хууль гэх мэт салбарт хуваагдаагүй бүгдийг хамтатгасан 10 хэсэгтэй. Хуулийг дотоод бүтцээр нь авч үзвэл зарлиг бичгийн зүйл 94, дүрмийн зүйл 1151, таслах дүрэм 717 байна.

Юань гүрний хууль цаазын онцлог нь монгол, хятад хүнд тусгайлан хандсан, тэдгээрийн хооронд үүссэн харилцааг ялгавартайгаар зохицуулсан тухайлбал, хятад хүнтэй холбоотой хууль нь эртний хятадын Күнзын сургаалд, монгол хүнд холбогдох цааз нь Их засаг болоод монголын хэв ёсны үндэс суурин дээр боловсруулагдсан байжээ.

Юань Улсын хуульд гэр бүлийн амьдралыг урьд оршин байсан Сүн, Алтан улсын үзэл баримтлал хийгээд Хятадын заншлын хэм хэмжээнд тулгуурлан тогтоожээ. Тухайлбал²⁰⁵, гэрлэгчид гэрлэлтийн гэрээ байгуулах ёстой бөгөөд гэрээ нь хүүгийн эцэг, хэрэв эцэг нь нас барсан бол эхээс зөвшөөрөл авснаар гэрлэх эрхтэй болно. Хэрэв уг гэрээнд тогтоосон хугацаанд хүндэтгэх шалтгаангүйгээр гэрлэх ёслолоо хийгээгүй болон завхайрсан этгээдүүдийн хооронд байгуулсан гэрээ тус тус хүчингүй болно гэж заажээ. Мөн төрөл садангийн хүн хоорондоо гэрлэх, захирагч хүн өөрийн харьяатны охинтой гэрлэх, дүү нь ахынхаа бэлэвсэн эхнэртэй гэрлэх, гашуудлын үед гэрлэхийн хориглож байв.

Юань гурний хаад монголчуудыг хятадуудтай холилдон уусах явдлаас сэргийлж Монгол Хятад хүмүүс ураг болох, монгол хүн хятад хувцас өмсөх, хятад зан заншилд орох зэргийг хуулиар чандлан хориглож байжээ.

Их Юань Улсын төр хятадын эртний эх сурвалжид уламжилж ирсэн өв залгамжлалын ёс горимыг үндсэндээ авч хэрэглэсэн байна. Дундад улсын эрх зүйн эх сурвалжид эхнэр нь эрийнхээ эд хөрөнгийг залгамжлах эрхгүй. Эр нь үхвэл түүний эд хөрөнгийг хамгийн түрүүнд хүү нь залгамжилж, эхнэр нь хүүгээрээ тэжээлгэнэ. Хэрэв хүү ба Амбул (ач) байхгүй бол эхнэр нь зөвхөн дахин ураглахгүй (гэрлэхгүй) нөхцөлд эрийнхээ үлдээсэн хөрөнгийг эзэмшиж болно. Хэрэв бэлбэсэн эхнэр нь хүү ба Амбул байхгүй нөхцөлд гэр өрхийн эд зүйлээ худалдвал түүний наймааны гэрээ хүчингүй болохоос гадна эрүүгийн ялаар яллагдана, бэлбэсэн эхнэр дахин ураглах үед үхсэн эрийнхээ эд хөрөнгийг авч явж болохгүй гэж тогтоожээ.

Юань Улсын ЮанДянЧжан хуульд нөхөр нь нас барвал хөвгүүдтэй тохиолдолд бүх өмч хөрөнгийг бэлбэсэн эхнэр авах бөгөөд хэрэв охинтой бол бүх хөрөнгийг охин нь авах бөлгөө. Хэд хэдэн хөвгүүд байвал хөрөнгийг адилхан хуваан авах ба нэг хоёр дахь эхнэрүүдийн хүүхдүүд адил эрхтэй аж. Нас барсан эцэг, эхийг оршуулаагүй байхад өмч хөрөнгийг хуваахыг хориглоно. Нас барагч цэргийн хүн байвал хүүгүй тохиолдолд хамгийн дотны хамтран зүтгэгчид нь түүний хөрөнгийг авах, харин талийгаач энгийн хүн байсан бол түүний овог төрлийн ах, дүү, ач, гуч нар нь авна гэжээ.

²⁰⁵Монгол Улсын түүх (дэд дэвтэр). Уб., 2003. 109 дэх тал.

Монгол цаазын бичиг: XVIII зууны үеийн Монголын эх сурвалж бөгөөд Манж, Монгол цаазын уламжлалыг тусган гэр бүлийн харилцаа, хүүхэд үрчлэн, асран тэтгэх харилцааг төрөлжүүлэн зохицуулж байсан²⁰⁶.

Манжийн засаглалын үеийн хууль цаазын дурсгалт эх сурвалж болох Монгол цаазын бичигт хийсэн хуульч эрдэмтдийн судалгаагаар²⁰⁷ хүүхдийн хөрөнгийн эрхийг зохицуулсан зарим заалт байна²⁰⁸. Тухайлбал, Үр тасарсан хүний гэр бараа, мал өвийг өвлүүлэх нь: Нэгэн зүйл. Гадаад монголын хүн бие нь өнгөрсний хойно үргүй бол амьд цагтаа төрлийн ах дүү нэрийн хөвгүүдээс баталж, өөр өөрийн засгийн ван, бэйл, бэйс, гүнгүүдэд тодорхой өгүүлээд хөвгүүн болгон тэжээсэн бол гэр мал өвийг нь өвлөтүгэй” гэжээ. Энэ нь өв залгамжлалаар төрсөн болон үрчлэн авсан хүүхдэд гэр бүлийн эд хөрөнгийг шилжүүлэх хэм хэмжээ болно.

Хүүхдийг үрчлэн авах, тэжээн тэтгэхтэй холбоотой харилцаа нь

1. Үрчлэн авч байгаа тал өөрийн хошууг захирагч зангид мэдүүлж төлөх дансанд;
2. Гадаад Монголын төрийг засах явдлыг яамны дансанд;
3. Хошууны сумын эрхийн дансанд тус тус тэмдэглүүлнэ. Үүний дараа тухайн хүнийг хүүхэд үрчлэн авсанд тооцож төрсөн хүүхдийн нэгэн адил эцгийн зэрэг, хэргэм, угсаа, гарал, эд хөрөнгийг залгамжлан авах эрхтэй билээ.

Үргүй хүн бус хөвгүүнийг авч тэжээх нь: аливаа хүн үргүй, бус хүний хөвгүүнийг авч тэжээвэл харьяат хошууны ван, ноёд хошууг захирагч занги нарт өгүүлж, Явдлын яамны дансанд тэмдэглэж, хөвгүүн болгон тэжээлгэж тэдний хошууны захирагч занги нарт өгүүлэлгүй зорилгоор авч тэжээвэл, тэжээсэн хөвгүүнийг татаж аваад, язгуурын хүнд тушаан өгч ялгүйгээр дуусга гэж тогтоож өгсөн.

Гэр бүл болохдоо инжийг хэрхэн тооцох талаар Монголчууд худ боллоцходогт богтлох мал өгөх нь: Хоёр харц хүн худ боллоцходогт богтлох мал хоёр морь, хоёр үхэр, хорин хонь ав. Дээрхээс давж илүү өгвөл, илүү малыг засагт ав. Дутуу бол ялгүй. Хүргэн үхвэл өгсөн малыг эргүүлж ав. Охин үхвэл хагаслаж ав. Эцэг, эх өгсүгэй хэмээхэд хүргэн айж үл авах бол өгсөн малыг хойш авахгүй. Худ болсон охиныг үл авах болоод охин хорин насанд хүрвэл эцэг, эхийн аль авах хүнд нь өг гэж инжийг хэмжээ, гэр бүл болоогүй бол эргүүлэн төлөх хэмжээг тогтоосон байна.

Бага насны, сэтгэцийн өвчтэй хүнийг асран хамгаалах, тэжээн тэтгэх талаар “Аливаа галзуурсан хүнийг түүний өөрийн эцэг, өвөг эх, бага авга хийгээд ах, дүү, өөрийн хөвгүүн ба ач нар нь ураг төрөлд нь тушаан өгч сахиул. Хэрэв омтгойлж алдуулаад хүн алахад хүрвэл ная ташуур жанчих тун” гэж хамгаалах субъект, түүний хэрэгжүүлэх арга хэмжээний талаар дурдаж болно. Сэтгэцийн өвчний улмаас эрх зүйн бүрэн чадамжгүй хүнийг түүний эцэг, эх, үр хүүхэд, ач зээ нар эдгээр хүмүүс байхгүй бол ураг төрлийн хүмүүс, ураг төрлийн хүн байхгүй бол тухайн оршин амьдрах нутгийн дарга, захирагч нар асран хамгаалах үүрэгтэй.

²⁰⁶Баярсайхан Б. Монгол цаазын бичиг. Уб., 2001.21 дэх тал.

²⁰⁷ Баярсайхан Б. Монгол цаазын бичигт хийсэн эрх зүйн судалгаа. Уб., 2004.

²⁰⁸ Сүхбаатар З. Батбаяр Б. нар. Дурдсан бүтээл. 30 дахь тал.

Мөн цаазад “Арван насанд хүрээгүй хүүхэд хологвол ялгүй. Арван наснаас дээш бол ялтай” гэж монголчууд дээр үеэс хүүхдээ бие бялдар, оюуны өв тэгш хүмүүжилтэй хүн болгох нь эцэг, эх, асран хамгаалагчийн эрхэм үүрэг байсаар ирсэн уламжлалтай. Монгол цаазын бичигт арван нас хүрээгүй хүүхэд бусдын мал, эд хөрөнгөд хохирол учруулсан тохиолдолд эрүүгийн цаазаар авч хэлэлцэхгүй гэсэн бөгөөд харин хохирлыг хэрхэн арилгах талаар хуульчлаагүй.

Өвлөх эрх, гэр бүлийн харилцааг эрт үеэс заншлын болон Их цааз, Халх журам хуулиудаар давхар зохицуулж ирсэн бөгөөд энэ нь Монгол цаазын бичигт утга санаа агуулгад уламжлан заасан байна. Тухайлбал, “Хоёр харц хүн худ бололцоход богтлох мал хоёр морь, хоёр үхэр, хорин хонь ав. Энэ цаазаас давж илүү өгвөл илүү малыг засагт ав. Дутуу бол ялгүй. Хүргэн үхвэл өгсөн малыг гэдэргэ, охин үхвэл хагасалж ав. Эцэг, эх өгсүгэй гэвэл хүргэн айж үл авах бол өгсөн малыг хойш үл авна. Худ болсон охиныг үл авах болоод охин хорин насанд хүрвэл эцэг, эхийн аль нэг дуртай газарт өг” хэмээн тогтоосон нь богтлох мал буюу бэлгийн хэмжээг хатуу тогтоож, түүний илүү өгснийг нь засаг хошууны дансанд хураан авч, цөөн өгөх нь ураг бололцож буй талуудын өөрсдийнх нь хэлэлцэж тохирсноор болдог байснаараа ялгагдана.

Алтан хааны цааз бичиг: Алтан хааны цаазнь ард түмний дунд түүхийн урт удаан хугацааны явцад дадал хэвшил болон тогтсон түүнийг төрөөс зөвшөөрч хамгаалсан заншлын хууль нөгөө талаас Чингисийн Их засаг зэрэг XIII зуунаас хойших монголын бичмэл хуулиуд байж болно гэж түүхчид дүгнэдэг²⁰⁹.

Түмэдийн Алтан хааны (1507-1582) өөрийн улсын хүчирхэг эмх цэгцтэй улс байлгахын тулд гаргасан цааз бөгөөд бүрэн эрхээрээ уламжлагдсан ирсэн Монголын эртний эрх зүйн бичгүүд дотроос хамгийн эртний цааз юм. Энэ цааз бичиг нь 115 зүйлтэй, оршил, төгсгөлийн хэсэгтэй ба эртний хэв хуулийн уламжлалд тулгуурлан тогтоогдсон болно. Алтан хааны цаазын эмхтгэлд 12 хэрэг багтах бөгөөд түүний 5 дахь хэсэгт “Эм, эр гэр бүлийн хэрэг”-ийг тус тус зохицуулсан байна. Энэ хэрэгт дараах хэргүүдийг хамааруулан оноох шийтгэлийг зааж өгсөн байна. Үүнд: 53-67 дахь хэсгүүдэд “Жирэмсэн эмийн ургийг унагаваас сарын тоолон есөөр торго”, “Эр нь эмийн үсийг тасадваас нэг таваар торго”, “Хувцсыг нь урваас нэг таваар торго”, “Эр эм самууран явалдваас долоон есөөр торго”, “Хүүхэн босговоос есөн есөөр торгож, нэг хэсэг жанч”, “Ор дэвсгэрээс нь татваас гурван есөөр торго”, “Эцэг эх нь охиноо элдэв аргаар эрд өгвөөс есөн есөөр торго, охин буцаж ирвээс цаазгүй”, “Санаа муутай хүнтэй зөвшилдвөөс долоон ес ав”, “Цэвэр бага охиныг гутааж эцэг, эх нь хүргэнд барьж өгвөөс эцэг эх нь цаазтай”, “Заяаны хүргэн болзоот хуримандаа явж байгаад зам зуураа нас нөхцвөл бүсгүйг хүргэний эцэг нь ав. Болзсон хуримаа хийгээгүй бол бүсгүйн эцэг эх мэд”, “Эр нь эхнэрээ ирт үзүүрт, мод, чулуу, шороогоор цохивоос гурван есөөр торго. Ташуур, нударга, хөлөөрөө цохивол нэг ес”, “Эм нь эрийгээ хэл амаар дайрваас нэг үхрээр торго”, “Хүргэн авах, бэр буулгахтай холбоотой зүйл байгаа ч тун ойлгомжгүй тул сэргээгдээгүй”, “Хүүхнийг хоёр хуримлахыг хориглосон, бэр буулгахдаа урьд хэлэлцсэн хүүхнийг заавал авах ёстойг заасан байгаа боловч төдий л тодорхойгүй тул сэргээсэнгүй”, “Эхнэр хүнийг татваас, хувцсыг нь урваас

²⁰⁹ Алтангэрэл Т. Энхээ Ц. ХҮІ-ХҮІІІ зууны монгол цаазын бичгүүд. Уб., 2003. 25 дахь тал.

морь үхэр ав"²¹⁰ гэж хүүхэд, эмэгтэйчүүдийн эрхийг хангахаас гадна гэр бүлийн харилцаанд тэгш эрхтэй байх нөхцөлийг тогтоосон нь ач холбогдолтой байгаа бөгөөд одоогийн манай Үндсэн хууль, Гэр бүлийн тухай хуульд заасан хүүхэд, нялхасын эрх ашгийг хамгаалах, гэр бүлийн гишүүд харилцаанд тэгш эрхтэй байх нөхцөлийг заасан гэж дүгнэж болохоор байна.

Уг эх сурвалжид гэр бүлийн хөрөнгийн эрхийн талаар дараах байдлаар тусгасан байна. Тухайлбал, Эр, эм гэр бүлийн хэрэг-жирэмсэн эхийн ураг хөндөх, эр нь эмийнхээ үс, хувцсыг тасдах, хувцсыг нь урах, эр, эмийн аль аль нь самууран явалдах, ор дэвсгэрээс нь татах, эцэг, эх нь охиноо элдэв аргаар эрд өгөх, санаа муутай хүнтэй зөвшилцөх, эр нь эхнэрээ ирт үзүүрт мод, чулуугаар цохих, эм нь эрийгээ ам хэлээр дайрах, эхнэр хүнийг татах, хувцсыг нь урах зэрэгт ес, таваар торгох, занчих, нэг бод буюу бог малаар торгох шийтгэл оноохоор заасан".

Цааз эрхэмтийн арван найман хууль: XVI зууны II хагас XVII зууны эхэн үеийн монгол цаазын үнэт дурсгалын нэг нь Цааз эрхэмтийн арван найман хууль билээ. Уг хуулийг XVI зууны II хагасаас XVII зууны дунд үе хүртэлх хугацаанд халхын дөрвөн хошуу, зургаан хошуу, долоон хошууны ноёдын арван найман удаагийн чуулганаар хэлэлцэж баталсан байна.

Уг хууль нь 10 төрлийн харилцааг зохицуулж байсны нэг нь гэр бүлийн харилцаа бөгөөд нэгдүгээр цааз буюу Хошууны цаазын 53-д Тэрчгүй хуримыг үрээ. Гэрчтэй болтугай, хорь насалсан охиныг өөрийн ноён, хүргэний ноёнд хүрч өг"²¹¹ гэж заажээ.

Монгол-Ойрадын их цааз: XVII зууны үед үйлчилж эхэлсэн 1640 оны 08 дугаар сарын эхээр дөрвөн ойрадын нутаг Тарвагатайн улаа бураа гэх газар Халх, Ойрадын ноёдын их хуралдаанаар хэлэлцэж баталсан хууль бол Монгол-Ойрадын их цааз юм. Түүнийг дөчин дөрвөн хоёрын цааз гэж нэрлэсэн бөгөөд хожмын судлаачид Монгол-Ойрадын их цааз, Монгол-Ойрадын цааз, Их цааз, Монгол-Ойрадын хууль, Халх-Ойрадын цаазын бичиг зэргээр нэрлэж байжээ²¹².

Монгол-Ойрадын хууль нь 186 зүйлтэй ба эд хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулахтай холбоотой Иргэний эрх зүйн харилцааг зохицуулахад чухал үүрэг гүйцэтгэсэн юм.

Уг хуулиар гэр бүлийн өмч нь хамтын өмч бөгөөд эмэгтэй хүний хэрэглэх зүү, утас, товч, шилбэ, хайч зэрэг олон зүйлийг нэрлэн зааж хэн ч үл хөндөж болох ба энэ нь эхнэрийн хувийн өмч гэж тодорхойлсон нь гэр бүлийн хөрөнгийн дэглэмийн анх удаа бий болгосныг харуулж байна.

Энэхүү түүхэн эх сурвалжид хүүхдийн хуваарьт хөрөнгийн эрхтэй холбогдолтой зарим заалт²¹³ байна гэж иргэний эрх зүй судлаачид тэмдэглэсэн байх бөгөөд тэдгээрийн нэг нь "Эцэг хөвүүндээ өмч хэвээр өг" гэж орчин цагаар гэр бүлийн гишүүдийн хамтран өмчлөх дундын эд хөрөнгөөс хүү нь өөрт ногдох хувийг өмчлөх эрхтэй гэсэн агуулгатай хэм хэмжээ гэж үзэж болно. Мөн тухайн

²¹⁰ Алтангэрэл Т. нар. Дурдсан бүтээл. 41-42 дахь тал.

²¹¹ Алтангэрэл Т. нар. Дурдсан бүтээл. 60 дахь тал.

²¹² Алтангэрэл Т. Монгол-Ойрадын Их цааз төр, эрх зүйн түүхэн эх сурвалж болох нь. Уб.. 2001. 17-18 дахь тал.

²¹³ Сүхбаатар З. Батбаяр Б. нар. Дурдсан бүтээл. 28 дахь тал.

үеийн гэр бүлийн хөрөнгөөс хүүд өмчлөх эрхийг шилжүүлэх бүрэн эрхийг эцэг нь эдлэх тухай хуульчилсан байдаг.

XVII зууны Монголын нийгмийн харилцааны чухал хэсэг болох гэр бүлийн эрх зүйн харилцааг зохицуулсан хэм хэмжээнүүдийг онцгойлон заажээ. Үүнд:

1. Гэрлэх насыг 14-20 гэж заагаад худ ураг бололцох, сүй бэлэг тавих, инж дагуулах ёс зэргийг хуульчлан зааж өгсөн юм.

Тухайлан авч үзвэл.32 дугаар зүйлд “Эцэг хүүдээ өмчөө хэвээр өг. Эцэг үгүйрвэл таваас нэгийг ав”, 33 дугаар зүйлд “Ямут ноёд тавнангуудын худ болохул малын тоо гучин бэрх, зуун тавин адуу, дөрвөн зуун хонь авах болов. Бага ноёд тавнангуудын авах малын тоо арвантаван бэрх, тавин адуу, зуун хонь, эд инжээ өгсөн малын хэр мэдэж өгөх болов. Үүнээс багасгахаа хоёр ургийн дур мэдтүгэй”, 34 дүгээр зүйлд “Дөчний дэмчийн хүүхний малын тоо таван тэмээ. хорин таван бод, дөчин хонь авах²¹⁴, өгөх эд арван захтай (өвлийн дээл) хорин задгай (дан дээл) эмээл хазаар, дээл цэгдэг, хоёр морины инж өг. Хүн инжтэй болвол тэмээ хомнож өг. Өгсөн эдийн хэр мэдэж хомнож өгтүгэй, 35 дугаар зүйлд “Хорины Шүүлэнгийн өгөх авах мал дөрвөн тэмээ, хорин бод, гучин хонь буй. Эд нь таван захтай, арван таван задгай, морь, тэмээ хоёр өг. Эдийн хэр мэдэж хомнож өг. Хиа нарын хэв энэ мал болтугай”, 36 дугаар зүйлд “Дунд хүний мал гурван тэмээ, арван таван бод, хорин хонь буй. Инж нь тэмээ, морь хоёр. Дөрвөн захтай, арван задгай, эдийн хэрийг мэдэж хомнож өг”, 37 дугаар зүйлд “Адаг хүний мал хоёр тэмээ, арван бод, арвантаван хонь буй. Морь, тэмээ, дээл цэгдэг, эмээл хазаар өгтүгэй”,38 дугаар зүйлд Арвандөрвөн настай хүүхнээс дээш авах болов. (эмэгтэйн гэрлэх нас 14-өөс дээш) доошихийг дэмч шүүлэнгэд хэлээд байтугай. (бүү гэрлүүл) Энэ цаазаас хэн хүн давбал хүүхнийг нь малгүй (сүй бэлэггүй) авч өгөх болов, 39 дүгээр зүйлд “Дөчний дэмчийн алш (хуримын зардалд хэрэглэх мал) дөрвөн бод, таван хонь буй. Хорины шүүлэнгийнх гурван бод, дөрвөн хонь, дунд хүн хоёр бод гурван хонь, адаг хүн нэг бод хоёр хонь”²¹⁵ хэмээн тус тус зохицуулсан байна.

Мөн яамт ноёд тавнангууд, бага ноёд, тавнангуудын худ ураг болохдоо өгөх малын тоог гучин бэрх, зуун тавин адуу, дөрвөл зуун хонь, арван таван бэрх, тавин адуу, зуун хонь гэх мэтээр заагаад тоо хэмжээг нь харилцан дураараа доошлуулж болно гэжээ. Үүнчлэн дөчний дэмч хорины шүүлэнг, дунд хүн, адаг хүн гэх мэтээр бүх давхрааныхны сүйд өгөх малын тоо, хуримын зардал, хэрэглэлийг нарийвчлан заасан байна.

2. Ийнхүү худ ураг бололцохдоо сүй тавьж ихээхэн мал хөрөнгийг бэлэг болгон өгдөг нь зарим судлаачдын бичдэгчлэн эмэгтэй хүнийг худалдаж, худалдан авч байгаа хэрэг биш харин

- Хадамд очиж байгаа эмэгтэй хүний нэр хүндийг өргөх, хүргэний тал
- Хүүгээ хуримлуулж гэр бүл болгох эдийн засгийн чадавхитай болохоо батлан харуулах
- Шинэ гэр бүлийн эдийн засгийн үндэс суурийг бат бэх тавих гэсэн бодлоготой уялдсан юм. Мөн эмэгтэй нь хадамд очихдоо сүй бэлгийн хэмжээтэй

²¹⁴Алтангэрэл Т. Дурдсан бүтээл. 55 дахь тал.

²¹⁵Мөн тэнд. 56 дахь тал.

тэнцэхүйц инж авч очихоос гадна өвөл зуны дээл хувцас 5-20 хүртэл тоогоор бэлдэж очихоор заасан нь дээрх дүгнэлтүүдийг батална.

3. “Арвандөрвөн настай хүүхнээс дээш авах болов. Доошийг дэмч, шүүлэнгэд хэлээд байтугай” гэсэн нь эмэгтэй хүний гэр бүл болох нас 14-өөс дээш бөгөөд түүнээс доошийг насанд хүрээгүй гэж үзэж гэрлэхийг хориглосныг харуулна. Түүнчлэн сүй тавьсан охиныг өөр айлд бэр болгох, эмэгтэйг сүй тавилгүй оргуулан авах зэргийг хориглосон байна.

4. Тэрчлэн жил бүр дөчнөөс дөрвөн шинэ гэр бүлийг үүсгэх ёстой бөгөөд арван айл хамтарч нэг залууг гэр бүл болоход нь гэр барьж өгөх зэргээр туслах үүрэгтэй гэж Их Цаазад заажээ. Ийнхүү гэр бүл болоход зөвхөн хүүхдүүдийн эцэг, эх төдийгүй нийт ард иргэд туслан дэмжих ёстойг заасан нь XVII зууны Монголын төрөөс гэр бүлийг бэхжүүлэх, тогтвор суурьшилтай байлгах талаар ихэд анхаарч байсны баталгаа мөн. Тухайлбал, 40 дүгээр зүйлд “Жил бүр дөчнөөс дөрвөн хүүд гэр авч өгтүгэй. Арван айл дэмнэж нэг гэр авч өгтүгэй. Эдээс нь бод өгвөл захтайг нь ав. Хонь өгвөл задгайг нь ав гэжээ. Энэ нь гэрлэгчдийн гэрийг нэг отог (дөчин гэр) газар буюу арван өрх нэгдэн нэг гэр, бүгд дөрвөн гэр бэлтгэж өгөхийг хууль зүйн хувьд тогтоосноороо онцлогтой байна. Мөн хурим найрын зардлыг хэрхэн бүрдүүлэх, түүнийг худ ураг бологсдын зэрэг дэв, хөрөнгө чинээг харгалзан ялгавартай тогтоосонд оршино. Үүнд, дөчний дэмчийн алш дөрвөн бод, таван хонь буй. Хорины шүүлэгийг гурван бод, дөрвөн хонь, дунд хүн хоёр бод, гурван хонь, адаг хүн нэг бод, хоёр хонь.

5. Цааз бичгийн 29 дүгээр зүйлд “Худ ураг бололцсон хадмын тал бэрээ хорин нас хүртэл авахгүй байвал бэрээ ав гэж 3 дахин шаард, авахгүй бол ноёндоо хэлээд өөр хүнд өгч болох” тухай заасан байна. Мөн гэр бүл салсан, гэрлэгсдийн аль нэг нь хуримлахын өмнө болон дараа нас барсан тохиолдолд өмч хөрөнгө, сүй бэлэг, инжийг хэрхэх тухай асуудлыг хуульчилжээ.²¹⁶ Тухайлбал, 42 дугаар зүйлд “Хорь хүрсэн хүүхний хадамд нь гурав хэл. Эс болвол ноёнд нь хэлж өг. (Сүй тавьсан хүүхнийг хорь хүртэл нь эс авбал ноёндоо хэлж өөр хүнд өгч болно) Хэлэлгүй өгвөл өгсөн малыг нь охины эцгээс ав. Цаазын хэвээр болтугай”, 43 дугаар зүйлд “Хуримласан охин үхвэл эд инжийг нь өг. Эс хуримласан бол малынхаа хагасыг ав. Дуулга, харавч, хуяг өгсөн бол дуулгаас тав, харавч, хуягаас тэмээ тэргүүтэй ес ав. Буу өгвөл тав ав”²¹⁷ хэмээн тогтоожээ.

6. Сүйг өөр хүнд өгөхийг хориглосон байна. Үүнд, 46 дугаар зүйлд охиноо хүнд өгөхөөр сүй тавьсан айлын эцэг, эх охиноо сүй тавьснаас өөр хүнд оргуулж өгвөл сайн хүнээс таван ес тэмээ тэргүүтэй, дундаас тэмээ тэргүүтэй гурван ес, адаг нь тэмээ тэргүүтэй ес, өгсөн малтай нь хамт охиноо авна. Харин охин өөрөө оргож өөр хүнд очсон бол гурван мал аваад түүнийг охины эцэг иднэ. Сүйгүй охиныг оргуулсан бол сайнаас долоо, дундаас тав, муугаас нэг тэмээ авна.

7. Талийгаачийн өмч хөрөнгийг хууль ёсны өвлөгчөө өөр хүн ашиглахыг хориглосон²¹⁸.

²¹⁶ Алтангэрэл Т. нар. Дурдсан бүтээл. 105-107 дахь тал.

²¹⁷ Мөн тэнд. 128 дахь тал.

²¹⁸ Рязановский В.А. Дурдсан бүтээл. 72 дахь тал.

8. Ураг барихыг хэлэлцэж инжийг хүргэсний хойно хүргэн өвчнөөр нас барсан бол өгсөн инжийг төлүүл, охин өвчнөөр нас барсан бол инжийн хэмжээний талаар төлүүл гэж гэр бүлийн харилцаанаас үүсэх үр дагаварыг тогтоожээ²¹⁹.

1640 оны Монгол-Ойрадын хуулиар Монгол, Ойрадын ноёдын дундах эвдрэлийг зохицуулах, эрүү, иргэн, засаг захиргааны харилцаа байсан. Гэр бүлийн эрх зүйн харилцааг хэрхэн зохицуулсан талаар цухас үзвэл: энэ үед гэрлэлтийг дэмжиж байсан нь хуулийн зохицуулалтаас харагдах бөгөөд энэ нь цэрэг эрчүүдийг бэлтгэхтэй холбоотой байсан болов уу. Тухайлбал, 40 өрхөөс тус бүр 3 хөвгүүнийг гэрлүүлж байх, 10 хамжиж тэдгээрийг гэрлэхэд туслаж байх зэрэг хэм хэмжээг хуульд тусгасан. Мөн тухайн үед эцгийн эрхт ёс давамгайлж нөхөр нь хаясан эхнэрээ албал 5 есөөр торгох, хүү нь эцгийнхээ зөвшөөрөлгүй эхнэр авах эрхгүй байсан байна. Охиноо эрд гарахын өмнө нөхөр болох инж авч сүй тавих, сүйн хэмжээ нь гэрлэж буй хүний нийгмийн гарлаар тодорхойлогддог байжээ. Ноён хүний охиныг авбал үнэт зүйл 30, адуу 150, хонь 400 авдаг байсан. Гэрлэсэн бүсгүй үхвэл эд инжийг нь өгдөггүй, харин гэрлээгүй бол хагаслаж өгдөг, бэр нь нас барсан бол инжийг нь буцаадаг байсан байна²²⁰. Марко Поло эрчүүд хэд хэдэн эхнэр авч болох ба эдгээр эхнэрүүдийн нэг нь их эхнэрт тооцогдоно гэж тэмдэглэсэн байна.

Дээрхээс гадна гэр бүлийн гишүүн, номын багш, боолынхоо биед гэмтэл учруулах, амь насыг нь хохироосон бол ямар шийтгэл оногдуулах талаар 26-31 дүгээр зүйлд зохицуулсан байна. Үүнд, аливаа хүн сургасан багшаа, эцэг, эх жанчвал гурван ес ав. дунд жанчвал хоёр ес ав, бага жанчвал ес ав; их жанчвал гуч цохь, дунд жанчвал хорь цохь, бага жанчвал арав цохь; эцэг хөвгүүн бэрээ сургаж жанчва ялгүй, буруугаар ес ав, дундаас тав, багаас нэг морь ав. Хадам нь бэрээ жанчвал хоёр ес ав. Дундаас ес, багаас тав ав; хүү нь эцэг, эхээ алвал үзсэн нь хүн ноёнд хүргэ. Бэр тэргүүтэй ес ид, биеэс бусыг нь тараах, эцэг нь хүүгээ алвал халуун аминаас бусыг нь авах болов; хүн боолоо алвал таван ёс ав, эм боолоо алвал гурван ес ав; салсан эхнэрээ алвал таван ес, хоёр эхнэрийн нэг нь нөгөөгөө алвалтаван ес болов, Эсвэл чихийг нь огтолж өөр хүнд өгнө.

Үйсэн цаазууд дахь иргэний эрхийн холбогдолтой зарим заалт: Хэн хүн эм босговоос эмээ эр нь авбаас оргүй. Эмийг эс авбаас хоёр бэрх ав. Гэрчгүй хуримыг үрье. Гэрчтэй болтугай. Хорь насалсан охиныг өөрийн ноён хүргэний ноёнд хүрч өг. Ноён хүний сүйтийг нь аваад хүнд өгвөөс тэр хүнээс анз аваад тэр эмийг хариулж өг. Ноён сүйтээ авалцахул тэр сүйтийг нь хагацуулаад арван гэр хүн мянган анз авах болов. Харц хүний сүйг нь хан хүн авбаас тэмээ, хуяг хоёрын нэгийг өг²²¹ гэж гэрлэлтийн үүсэх хэлбэр, түүний үр дагаварын талаар тодорхой заажээ.

Халх журам: XYIII зууны эхэн үеийн Монголын төр, эрх зүйн түүхэн эх сурвалж болох “Халх журам”-ыг 1709-1795 оны хооронд халхын хаад, ноёд, төр, шашны томоохон зүтгэлтнүүд бүгд 20 гаруй удаа янз бүрийн газар цуглаж

²¹⁹Зарлигаар тогтоосон Монгол Улсын хууль зүйлийн бичиг. УБ., 2010. 142 дахь тал.

²²⁰Аюирмэд Э. Дашцэдэн Д. Совд Г. Дурдсан бүтээл. 81 дэх тал.

²²¹Сүхбаатар З. Батбаяр Б нар. Дурдсан бүтээл. 27 дахь тал.

хэлэлцэн тогтоосон²²² эрхийн акт юм. Уг хууль нь Манжид эзлэгдсэнээс хойш 18 жилийн дараа гарсан учир Монгол орон, Манж гүрний төрийн бодлого, хүний хөгжил, эрх зүйн зохицуулалт зэргийн түүхэн нөхцөл байдалд нийцүүлэн тогтоосон.

Уг хуулийн гуравдугаар бүлэгт “Гэрлэлт, гэр бүлийн тухай хууль”-ийг анх удаа бий болгож гэр бүлийн харилцааг зохицуулахад баримталж ирсэн гол зарчмыг тусгажээ. Тухайлбал, олон эхнэртэй байж болохгүй, гэр бүлээс гадуур садар самуун явдал байж болохгүй, гэр бүлийн гишүүд эхнэр, нөхөр харьцангуй эрх тэгш байх, гэр бүл болохдоо сүй бэлэг, инж солилцох, гэр бүлийн хөрөнгийн эрх тэр дундаа хүүхдийн хуваарьт хөрөнгийн эрхийн холбогдолтой зарим заалтууд нь эд хөрөнгө, гэр бүлийн тогтвортой байдал, иргэд хоорондын маргааныг шийдэхдээ ял шийтгэлийн хэлбэрээр торгууль ногдуулсан зохицуулалтуудтай байжээ.

Уг хуулийн 78-103 дугаар зүйлүүдэд гэр бүлийн харилцааг дараах байдлаар зохицуулсан байна. Үүнд:

1. Гэр бүл болсон хүнтэй гэр бүл болохыг хориглож зөрчсөн тохиолдолд малаар торгож төрийн өмч болгодог байсан²²³.

Тухайлбал, 78 дугаар зүйлд “Ноён нь ноёд, тайж, язгууртны охиныг хоёр дахь авхай болгон өгвөөстөр өгөгч ноёныг арван тэмээ, зуун адуугаар баалъя. Энэ бааг засаг захиргааны эрх барьж байгаа ноёд автугай, 79 дүгээр зүйлд “Засаг барьсан ноёд биеэр хошууддаа авай дээр авай өгвөөс засгийн ноёдыг арван таван тэмээ, зуун тавин адуугаар баалъя. Энэ бааг гурван хошууны цааз буюу Халх журмыг зохиож батлахад оролцсон хүмүүст өгье. Тавнанг таван есөөр торгож, торгосон малыг урьд авайд өгч, авай язгууртан дагуулж ирсэн инжээ аван төрхөмдөө харих, 80 дугаар зүйлд “Авай дээр биеэ мэдэж очвоос хойт авайг хагацуулъя. Тавнанг таван есөөр торгоё. Торгосон малыг засагт автугай. Засаг нь мэдэж байж дарваас гурван хошууны засгийн ноёд хурааж автугай”, 81 дүгээр зүйлд “Тавнанг авайг хаявал гэрээсээ мал авалгүй ганцаараа явах, тонилох. Авай инжээ авч хошуундаа биеэ мэдэх, Тавнангийн авсан эд малыг хувааж хагасыг нь засагтаа авах, авайд өгөх, 82 дугаар зүйлд Авай дээр харц эм авбаас эмийг нь зөвшөөрөхгүй. Тавнанг ная ташуурдъя. Эм авсан тул авай уурлаж тавнангаас хагацваас хойт авсан харц эмийг салгая. Бус ял нь ёсоор болох” гэж зохицуулсан байна. Монголчууд өмчлөх эрхийг зохих хэмжээний хүрээнд хүлээн зөвшөөрч түүнийг эрх зүйн актаар баталгаажуулж байсан ба эмэгтэйчүүд, хүүхдийн өмчлөх эрхийн хувьд гэр бүлийн тэгш эрхт гишүүн байсныг харуулж байна.

2. Гэр бүл болохоор инж өгч сүй тавьдаг байсан бөгөөд сүй тавиад хуримлаагүй бол сүйг буцаан авдаг байсан байна. Мөн сүй тавих эмэгтэйг солих, сүйгүй охиныг авах талаар тогтоосон байна.

Тухайлбал, 82 дугаар зүйлд “Авай инж болоод сүрэг мал, гэрээ аван хошуун дотроо биеэ мэд, 83 дугаар зүйлд “Нэг ноён нөгөө ноёныхоо сүйт охиныг авбал гурван өрх хүн, гурван зуун анзуугаар торгоё. Гурван өрхийн нэгийг ямбагүй хүн сонгож ав. Хоёр өрхийг ноён нь мэднэ. Авсан сүйтийг буцаая,

²²² Жалан-Аажав С. Халх журам. Уб., 1995. 7 дахь тал.

²²³ Жалан-Аажав С. Дурдсан бүтээл. 25-26 дахь тал.

84 дугаар зүйлд “Ноёд гурван хошууд дотроо харц хүний сүйг авбал нэг тэмээ өгөөд, хошуун дотроо сүйгүй охиныг сонгож авахыг зөвшөөрнө”, 91 дүгээр зүйлд “Хэн хүн сүйт охиныг сүйгүй ноёнд худал хэлж авбаас салгаж анх сүй тавьсан хүнд өгөх, Худал хэлсэн хүний эд малыг хагасыг авах”, 92 дугаар зүйлд “Хаан хүний охин авайг харц хүн сүйлбэл цагаан тэмээ мөнгөн буйлтай, цагаан морь булган молцогтой, мөнгөн аяга архиар дүүрсэн, нүхгүй сувд эрдэнэ эдгээрээр сүйлснийг сүй дор тооцно”, 93 дугаар зүйлд “Ноёд, тавнангуудын охиныг гуйваас мөнгөн аяга, сувд, архи өгвөөс тооцно. Үгүй бол тооцохгүй”, 94 дүгээр зүйлд “Харц хүн сүйлбэл архи болоод хонины гэдэс дотор, эвэр туурай гүйцэд болбоос тооцох, гэрч үгүй ба гэрч эс мэдвээс тооцохгүй”, 95 дугаар зүйлд “Худ талын хүнд малын хээл хэдийд авсан байх хугацааг харгалзан тэмээг өвлийн сүүл сард, гүүг зуны сүүл сард, үхрийг намрын сүүл сард, хонийг намрын дунд сард өгөх”, 96 дугаар зүйлд “Ер худ болсон хүн малаа аваад охиноо өгөхгүй явсаар жил өнгөрсний дараа охиныг эцгээс авч яваад дотор, анх өгсөн малын тоогоор эргүүлж өг, хоёр жил болсон бол малын хагасыг дахин нэмж өгнө, гурван жил өнгөрсөн бол анх өгсөн малыг хоёр дахин нэмж өгнө. Хүүгийн эцэг охиныг авч явбал мал зуу бол түүнийгээ авах, жилийн хэмжээ арван хоёр сар байна”, 97 дугаар зүйлд “Сүйлсэн хүү, охин авалцахын урьд хэнд өгсөн байваас өгсөн малаа хариулж автугай, 98 дугаар зүйлд “Мал өгөлгүй хүчээр хүргэн орж, эм аваад өөрөө салж явсан бол арван бод, гучин хонь өг. Явсан хүнийг эргэж эрүүлсэн бол найман бод, хорин хонь өгнө”, 103 дугаар зүйлд “Хаан хүн харцад өөрөө охиноо өгсөн, харц, хаан хүнд өөрөө барьсан бол хариуд нь мал өгөхгүй” гэж тус тус хуульчилсан байна. Гэрлэлтийн харилцаанд эд хөрөнгө, нэр төр үндсэн гол хүчин зүйл байсан байна.

3. Гэр бүл болохдоо хуримладаг байсан байна. Тухайлбал, 89 дүгээр зүйлд “Ноёд хуримласан хүүхдээ өөр тавнанд өгвөл таван хошуу мал оролцуулан тавин таван малаар торгоё. Хурим хийлгүйгээр охиноо өөр хүнд өгвөл урьд авсан малыг эргүүлж өг”, 90 дугаар зүйлд “Ноёд харц хүний сүй тавьсан хуримлахаар болсон эмийг сүй тавиагүй хүнд өгөхөөр бол хуримт хүний ноёнд нь сонсгож өг. Сонсголгүй өгвөл язгуурын хуримт хүнд буцааж өг, буцааж өгөөгүй бол зуун мал торгууль өг”, 91 дүгээр зүйлд “Хэн хүн сүйт охиныг сүйгүй ноёнд худал хэлж салгаж авч өгвөл анх сүй тавьсан хүнд өгч худал хэлэгчийн эд малын хагасыг авах” гэж шийтгэлийг торгуулийн хэлбэрээр зохицуулсан байна.

4. Гэр бүлээс гадуур харилцааг хориглодог байсан. Тухайлбал, 85 дугаар зүйлд “Ноёд ноёдын хатантай явалдвал ноёд дотроо сүй эвдсэнтэй адил тооцож, гурван өрх хүн, гурван зуун малаар торгох, биеийг нь авна”, 86 дугаар зүйлд “Ноёр харц хүний эмтэй явалдваас зуун тавин малаар торго. Харц хүн хатантай явалдваас боол болго”, 87 дугаар зүйлд “Харц хүн харц хүний эмтэй явалдваас морь, тэмээ, хонь ямаа тус бүр гуч бугд нийлээд зуун хорин бог, бод тэргүүтэй гурван зуун малаар торго. Дээрх малыг төлж чадахгүй бол нэг бодыг хорин таван ташуур, ташуурыг зуугаас байхаар тооцно”, 88 дугаар зүйлд “Хүний эм болон охиныг оргуулсан хүнийг хүний авгайтай явалдсантай адил тооцно”, 99 дүгээр зүйлд “Үхсэн хүний эмийг ноён хүнд өгвөөс тэр эм хөвгүүн хэд байвч хойт эртэй малад хүн бүр адил хувааж аваад, хүүхэд нь албандаа гартугай”, 100 дугаар

зүйлд" Төрсөн нагацдаа ууган, отгон хоёр зээ нь ялгүй. Нагац эцэг үгүй бол мөн ууган, отгон хоёр хүүд нь ялгүй" гэж тогтоосон байна.

5. Хүүхдийн эд хөрөнгийн талаар 702 дугаар зүйлд"Ноёд хүүхэддээ өмч өгөхдөө хаанд айлтгажзасгийн ноёндoo тэмдэглүүлж тамгалуул.Тэмдэггүй болоод заргабулаалцалдваас гэрч, тэмдэггүй болох болхүүхдийн хэлэх үгийг харгалзан үзнэ. үг баримт болгож тооцож үл болохыг хэлж буй). Хөрөнгийн талаар тэмдэггүй бол заргалдаж байгаа хоёр хүүхдээс бусдад нь хувааж өгөх, булаалцалдаж байгаа хүүхдүүдийн эх нь мэд" хэмээн гэр бүл дэх хүүхдийн эд хөрөнгийн талаар зохицуулсан байна.

1789 онд манжийн эрх баригчид гадаад монголын төрийг засах явдлын яамны хууль зүйлийн бичиг хэмээх 102 дэвтэр хууль батлан дагаж мөрдүүлэх болсноор "Халх журам" хуулийн үйлчлэл дуусгавар болжээ.

Зарлигаар тогтоосон Монгол Улсын хууль зүйлийн бичиг: Ураг барилдах ёслолын хууль хэмээх 27 дугаар дэвтэрт, хаан, ван, Богд хаант Монгол Улсын үеийн эрх зүйн түүхэн эх сурвалж болох "Зарлигаар тогтоосон Монгол Улсын хууль зүйлийн бичиг"-т хүүхдийн хуваарьтхөрөнгийн эрхийн холбогдолтой зарим заалт ²²⁴ -ууд хуульчлагдсан байна. Тухайлбал,"Үр тасарсан хүний эд хөрөнгийг эзэрхэх: Үр тасарсан хүний эд хөрөнгийг нэгэн төрлөөс хөвүүн тэжээсэнгүй болбоос төрсөн охин эзэрхтүгэй" гэжээ.

Тухайн үед эцэг, эх нас барахад түүний хөвгүүн уламжлалт заншил болон төрийн хуульд зааснаар очиж байхаар хуульчилжээ. "Хүчний хүргэн (сүй бэлэггүй хадам эцгийн гэрт түүний охинтой ханьсан ураг холбож нэр өрх гэрт аж төрөх эр) оруулахад эрх үгүй зуучны өмнө тодорхой бичиг байгуулж хөгширтөл тэжээх эсвэл гэрээс гарах жилийн хугацааг бичигтүн. Хүний ганц хүү болбоос бүү хүчний хүргэн болгон оруулагтун"гэж гэрлэлтийн нэг хэлбэрийн заажээ. "Шашин шүтлэг нийлэхгүй гадаадын хүнтэй эм охиныг харилцан гэргий болгож авбаас, өгвөөс болохгүй" гэж заасан нь Монгол үндэс угсаа, шашин шүтлэгээ ариунаар хадгалах санааг агуулсан байна.

1811 онд Зарлигаар тогтоосон Гадаад Монголын төрийг засах явдлын яамны хууль зүйлийн бичгийн Ураг бололцох ёслол хэмээх хорин тавдугаар дэвтрийн Бусдын богтолсон гэргийг аргалж авах нь 845 дугаар зүйлд ... засаг ба засаг ван, бэйл, бэйс, гүн, тайж, тавнан²²⁵ аргалж бусад богтлон тогтсон гэргийг авбаас хэрэг гарч ирсний хойно авсан, өгсөн хоёр этгээдэд ван, бэйл, бэйс, гүн болбоос таван есөн мал, харц хүн болбоос гурваад есөн малаар торгож, бүгдийг уг богтлон тогтсон хүн өг. Зоригор авсан гэргийг салгаад язгуур нөхөрт өгч, агуулах гээхийг түүний дураар бологтун ...²²⁶ гэжээ. Эндээс үзвэл Монгол төрийн түшээд Манжийн засгаас монгол эмэгтэйчүүдийг богтлон өгсөн, авсан явдалтай тэмцэх асуудалд онцгойлон анхаарч төрийн бодлогын түвшинд тэмцэж байжээ.

²²⁴Сүхбаатар З. Батбаяр Б. нар. Дурдсан бүтээл. 45 дахь тал.

²²⁵Тавнан-1. Хаад ноёдын хүргэн 2. Манжийн хаанаас гүнж авсан хүн. Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь IV боть. Ерөнхий редактор Л.Болд. Шинжлэх ухааны академи. Уб., 2008. 1878 дахь тал.

²²⁶Амарсанаа Ж. нар. Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхтгэл. I боть. Уб.. 2010. 412-413 дахь тал.

Ван. гүнгүүд харц хүний гэргийтэй, харц хүн хатадтай явалдах, тайж нарын гэрийн боол тайж нарын гэргийтэй, харц хүн харцын гэргийтэй явалдсан бол пүнлүү хасах, дөнгөлөх, торгох, ташуурдах зэрэг арга хэмжээ авдаг байжээ.

Өв залгамжлах хөвгүүнгүй бол өвийг хэнд шилжүүлэх талаар тодорхой заажээ. Тухайлбал, тайж нас барахад төрсөн хөвгүүнгүй бол түүний төрсөн ах, дүү эд хөрөнгийг авах хэрэв ах, дүүгийн хөвгүүнийг үрчлэн авсан бол уг хүүхэд өвлөх эрх эдэлдэг байна.

Дүгнэлт:

Манай улс 1926 оны анхны Иргэний хууль үйлчилж эхлэхээс өмнө гэр бүлийн эрх зүйн харилцааг зохицуулж байсан арвин туршлагатай ард түмэн бөгөөд Хууль цаазын бичгүүдэд гэр бүл болох, гэрлэлтийн харилцаа, тэтгэмж, өвлөх эрхийн харилцаа зэрэг гэр бүл, хүүхдийн эрх ашгийг хамгаалж байсан хэм хэмжээ Монголын тулгуур төр байгуулагдсан үеэс зохицуулагдсан байсан гэж үзэхээр байна.

Түүхэн явцад гэр бүл болохдоо богтлох, инжинд өгөх, сүй тавих хэлбэрээр үүсч байсан нь төрт ёсны уламжлал, нийгмийн харилцаатай холбоотой байжээ.

XVIII зуун хүртэл гэр бүлийн харилцаа заншлын хэм хэмжээг зохицуулагдаж байсан ба Монгол цаазын бичигт төрөлжүүлэн, Монгол-Ойрадын хуульд нарийвчлан Халх журам хуульд тусгайлан Гэрлэлт, гэр бүлийн тухай хуулиар зохицуулсан ирсэн тухай түүхэнд тэмдэглэгдсэн байна.

Эртний хууль цаазын бичгүүдэд гэр бүл болох нөхцөл, гэр бүл болохдоо сүй тавих, бэлэг, инж солилцох, гэрлэгчдийн эрх, үүрэг, гэрлэгч болон хүүхдийн хөрөнгийн эрх, гэр бүлийн тогтвортой байдал, гэр бүлийн маргаанд оногдуулах арга хэмжээ зэргийг зохицуулсан нь одоогийн гэр бүл, өмчийн эрх зүйн хэм хэмжээний үндэс суурийг тавьсан гэж дүгнэв. Гэр бүлийн дундын эд хөрөнгөтэй холбоотой хэм хэмжээнээс өв залгамжлалын харилцаатай холбоотой хэм хэмжээ түгээмэл байжээ.

Эх сурвалжийн жагсаалт:

Бадарчи С. Их Монгол Улсын шүүх, шүүгчид, шүүгчдийн үйл ажиллагаа //Гэмт явдалтай тэмцэх асуудал. Онол арга зүйн улирал тутмын сэтгүүл. 2007. №2(20).

Болдбаатар Ж. Монголын төр ёсны уламжлал, шинэчлэлийн асуудлууд. Монголын төр, эрх зүйн түүхэн уламжлал, орчин үе. Олон улсын Эрдэм шинжилгээний бага хурал. Уб., 2006.

Майкий И.М. Чингис хаан. Вопросы истории. 1962. №5.

Авирмэд Э. Дашцэдэн Д. Совд Г. Монгол хууль. Уб., 1997.

Алтангэрэл Т. Монгол-Ойрадын Их цааз төр, эрх зүйн түүхэн эх сурвалж болох нь. Уб., 2001.

Алтангэрэл Т. Энхээ Ц. ХҮІ-ХҮІІІ зууны монгол цаазын бичгүүд. Уб., 2003.

Амарсанаа Ж. нар. Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхтгэл. I боть. Уб., 2010.

Батбаатар А. Монгол Улсын гэр бүлийн эрх зүйн зарим асуудал. Уб., 2007.

Баярсайхан Б. Монгол цаазын бичиг. Уб., 2001.

Баярсайхан Б. Монгол цаазын бичигт хийсэн эрх зүйн судалгаа. Уб., 2004.

Буянхишиг Б. Иргэний эрх зүйн удиртгал, Уб., 2012.

Дашням И. Чингисийн хаант улсын төр, хууль цааз, Уб., 1997.

Жалан-Аажав С. Халх журам. Уб., 1995.

Зарлигаар тогтоосон Монгол Улсын хууль зүйлийн бичиг. Уб., 2010.

Лүндээжанцан Д. Болдбаатар Ж. Монгол Улсын төр, эрх зүйн түүхэн уламжлал. Уб., 1997.

Ням-Осор Н. Мөнх тэнгэрээс соёрхсон Чингис хааны зарлиг буюу Их засаг хуулийн тайлбар. Уб., 2003.

Монгол Улсын түүх (дэд дэвтэр). Уб., 2003.

Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь IV боть. Ерөнхий редактор Л.Болд. Шинжлэх ухааны академи. Уб., 2008.

Мөнхжаргал Т. Гэр бүлийн эрх зүй. Уб., 1995.

Мөнхжаргал Т. Монгол Улсын иргэний хууль цаазын товчоон. Уб., 2006.

Рязановский В.А. Монголчуудын хууль цаазын дурсгал бичгүүдийн түүхэн тойм. Их засаг хууль. Уб., 2000.

Сүхбаатар З. Батбаяр Б. нар. Монгол Улсын Иргэний хууль тогтоомж, түүхэн эмхтгэл. Уб., 2012.

Эзэн Богд Чингисийн Их засаг. Уб., 1995.